БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Богд сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код:** БНА-2019/143/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Баянхонгор хот 2019 он


Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат

Утас: 99007576 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Цэцэгмаа

Утас: 88089024 Цахим хаяг: tsetsegmaadam@audit.gov.mn

Аудитор: Б.Азбаяр

Утас: 99061429 Цахим хаяг: azbayarb@audit.gov.mn


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

# Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| АОУС | Аудитын Олон Улсын Стандарт |

# Агуулга

1 Аудитын гэрчилгээ ..... 3
2 Аудитын тайлан ..... 5
2.1. Оршил ..... 5
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага ..... 5
2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт ..... 5
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин ..... 6
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ ..... 7
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал ..... 7
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар ..... 8
2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн ..... 8
2.8.1. Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал ..... 9
2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал ..... 9
2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга ..... 9
2.11. Шилэн дансны мэдээлэл ..... 9
2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга ..... 10
2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл ..... 10
3 Аудит хийсэн санхүүгийн тайлан ..... 11
3.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан ..... 11
3.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан ..... 11
3.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан ..... 13
3.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ..... 14
3.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ..... 15

# 1 Аудитын гэрчилгээ

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
64101 Номгон, Баянхонгор сум
Утас, факс 70-44-25-84
E-mail; bayankhongor@audit.gov.mn

2019.02.25 № 2/93

танай ______________-ны №______________-т

БОГД СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН ТӨСВИЙН ЗАХИРАГЧ Л.БУМТИРМАА ТАНАА

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т заасны дагуу Богд сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

**Зөрчилгүй санал дүгнэлт**

Богд сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

**Санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Богд сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл,санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

2519172

E:\ajil\2019 on\STA 2018\9.BogdEBS\4.Tailagnal\Аудитын гэрчилгээ.docx

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

**Үүрэг хариуцлага**

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудитын хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.МӨНХБАТ

E:\ajil\2019 on\STA 2018

# 2 Аудитын тайлан

## 2.1. Оршил

Богд сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг захирал Л.Бумтирмаад танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

## 2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Богд сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Богд сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019.01.25-наас 2019.02.25–ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019.02.25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Баянхонгор аймаг дахь төрийн аудитын газрын Б. Азбаяр хариуцаж хэрэгжүүлэв.

Богд сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Баянхонгор аймаг дахь төрийн аудитын газарт 2019.01.02-ны өдрийн 02 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

## 2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

### 2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Богд сумын Ерөнхий боловсролын сургуулийн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Богд сумын Ерөнхий боловсролын сургууль Хүүхэд бүрт-ахиц амжилт, хөгжил дэвшил, Эцэг эх бүрт- идэвхи оролцоо, сэтгэл ханамж, Багш бүрт- Шинэ санаа, шилдэг арга, ажилчин бүрт чин сэтгэл хариуцлагатай байдал, Ажилтан бүрт-ухаалаг дэмжлэг, урамтай харилцааг төлөвшүүлсэн шилдэг сургууль болох.

Үйл ажиллагааны чиглэл:

Бага дунд боловсролын тухай хуулиар Богд сумын Ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Эх хэлээрээ утга төгөлдөр найруулж бичих, ярих чадвар, гадаад хэлний зохих мэдлэг эзэмшүүлэх;
- байгаль, нийгэм, хүмүүнлэг, математик, мэдээлэл зүйн шинжлэх ухааны үндсийг эзэмшүүлэх;
- Мэргэжлийн чиг баримжаа олгож, бие даан амьдарч, хөдөлмөрлөх, үргэлжлүүлэн суралцахад бэлтгэх;
- Бие бялдраа хөгжүүлж, эрүүл аж төрөх ёсыг сахих, гэр бүлийн болон амьдрал ахуйгаа хөтлөх, хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, өөрийгөө хамгаалах арга барилд сургах, эх оронч, хууль ёсыг дээдлэх үзэл төлөвшүүлэх.

Богд сумын Ерөнхий боловсролын сургуулийн үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Богд сумын Ерөнхий боловсролын сургуулийн удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн

байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хууль
- Бага дунд боловсролын тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт ороогүй байна.

### 2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцэж байна.

Богд сумын Ерөнхий боловсролын сургуулийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн түвэгтэй байдлыг үнэлэхэд эрсдэлгүй буюу мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул томилогдсон аудитор гүйцэтгэлээ.

Богд сумын Ерөнхий боловсролын сургуулийн санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Санхүүгийн тооцоолох" ХХК-ийн Acolous” программ хангамж ашигладаг байна.

Богд сумын Ерөнхий боловсролын сургуулийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

### 2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Богд сумын Ерөнхий боловсролын сургуулийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 7 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

### 2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр Нийт зардлын 2 хувиар сонгов.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын үзүүлэлтийг үр дүнгийн тайлангийн нийт зардлаар сонгосон ба аккруэл сууриар бэлтгэгдсэн санхүүгийн тайлангийн хувьд дээрх үзүүлэлтийг суурь болгож авах нь зүйтэй гэж үзлээ.

Богд сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2018 оны Нийт зардал 960620.9 мянган төгрөг бөгөөд түүний 2 хувь болох 19212.4 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 2 хувиар тооцсон нь эрсдлийн түвшинтэй холбоотой юм.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

### 2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 5 чиглэлээр аудитын 7 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 1 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 6 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэв.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй
асуудлыг ангилсан байдал

(сая төгрөгөөр)

| № | Шийдэл | Тоо | Дүн | Тайлбар |
|---|---|---|---|---|
| 1 | Зөвлөмж өгсөн | 1 | 0.00 | |
| 2 | Төлбөрийн акт тогтоосон | 0 | 1.10 | |
| 3 | Албан шаардлага өгсөн | 0 | 0.00 | |
| 4 | Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн | 0 | 0.00 | |
| 5 | Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн | 0 | 0.00 | |
| | **Дүн** | **1** | **1.10** | |

**2.8.1. Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал**

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

2.8.1.1. ХХОАТ-т 1073.6 мянган төгрөг илүү шилжүүлсэн байхад авлагаар тусгаагүй.

**2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал**

Байхгүй

**2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Богд сумын Ерөнхий боловсролын сургуулийн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 2018 онд 789.7 сая төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 788.9 сая төгрөг буюу 99,9 хувьтай байгаа нь Хоол хүнсний зардал 661.3 мянган хэмнэгдсэнээс шалтгаалжээ.

**2.11. Шилэн дансны мэдээлэл**

Богд сумын Ерөнхий боловсролын сургуулийн Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн дагуу тогтоосон хугацаанд мэдээлбэл зохих 25 мэдээнээс 23 мэдээг хугацаанд нь байршуулж 2 мэдээ хугацаа хоцорч мэдээлсэн, 7

хоногийн дотор мэдээлбэл зохих 1082.6 сая төгрөгийн 41 гүйлгээнээс 1068.4 мянган төгрөгийн 40 гүйлгээг хугацаанд нь мэдээлж 14.2 сая төгрөгийн 1 гүйлгээг мэдээлээгүй тул Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хийгдэж буй аудитаар зөрчил арилгах албан шаардлага хүргүүлэв.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

### 2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт 2018 оны жилийн эцсийн байдлаар 100 хувьтай байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

### 2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Богд сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Богд сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

# 3 Аудит хийсэн санхүүгийн тайлан

## 3.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **84,174,258.15** | **108,829,708.15** |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 84,174,258.15 | 108,829,708.15 |
| **354** | **Хангамжийн материал** | 84,174,258.15 | 108,829,708.15 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 1,476,100.00 | 1,281,100.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 79,068,658.15 | 103,219,658.15 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 374,000.00 | 00.00 |
| 35460 | Хүнсний материал | 00.00 | 1,073,450.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 3,255,500.00 | 3,255,500.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **913,578,150.94** | **872,579,440.00** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 913,578,150.94 | 872,579,440.00 |
| **392** | **Биет хөрөнгө** | 913,578,150.94 | 832,003,440.00 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 1,441,667,775.00 | 751,970,902.80 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -745,454,613.39 | -85,995,266.55 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 306,609,262.78 | 313,189,262.78 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -172,132,192.11 | -207,597,723.55 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 124,701,367.19 | 115,818,933.74 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -83,129,714.02 | -86,740,977.71 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 12,000,000.00 | 12,000,000.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -5,375,000.31 | -6,275,000.31 |
| 39217 | Ном | 34,691,265.80 | 25,633,308.80 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 00.00 | 40,576,000.00 |
| 39301 | Програм хангамж | 300,000.00 | 300,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -300,000.00 | -300,000.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 00.00 | 40,576,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **997,752,409.09** | **981,409,148.15** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **755,835.00** | **00.00** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 755,835.00 | 00.00 |
| **413** | **Өглөг** | 755,835.00 | 00.00 |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | 755,835.00 | 00.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **996,996,574.09** | **981,409,148.15** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 996,996,574.09 | 981,409,148.15 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 784,407,989.49 | 824,983,989.49 |
| 51101 | Өмч: - төрийн | 784,407,989.49 | 824,983,989.49 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | -34,464,298.41 | -16,409,052.36 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | -34,464,298.41 | -34,464,298.41 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 18,055,246.05 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 247,052,883.01 | 172,834,211.02 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **997,752,409.09** | **981,409,148.15** |

## 3.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **963,110,210.62** | **978,676,226.22** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **20,621,573.82** | **180,161,481.92** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 20,621,573.82 | 180,161,481.92 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 20,621,573.82 | 180,161,481.92 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 860,000.00 | 500,000.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 23,210.00 | 00.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 19,738,363.82 | 179,661,481.92 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **121,246,036.80** | **9,348,944.30** |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 821,242,600.00 | 789,165,800.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 12,850,600.00 | 7,764,788.30 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 12,850,600.00 | 7,764,788.30 |
| **1330** | **Төсвийн захирагчдаас** | 83,114,983.80 | 00.00 |
| 133003 | Хөрөнгийн | 83,114,983.80 | 00.00 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 25,280,453.00 | 1,584,156.00 |
| 134001 | Нийгмийн даатгалын сангаас санхүүжих | 25,280,453.00 | 1,584,156.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **926,957,040.14** | **921,488,450.57** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **820,212,802.14** | **921,488,450.57** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 820,212,802.14 | 879,992,258.69 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 477,049,314.00 | 506,569,547.70 |
| 210101 | Үндсэн цалин | 477,049,314.00 | 506,569,547.70 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 53,122,299.00 | 60,505,450.72 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 53,122,299.00 | 49,810,275.72 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 00.00 | 1,388,031.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 00.00 | 1,576,347.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 00.00 | 370,162.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 00.00 | 7,360,635.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 107,524,474.00 | 105,839,704.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 8,365,114.00 | 6,965,314.00 |
| 210302 | Түлш, халаалт | 97,419,960.00 | 98,244,390.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,739,400.00 | 630,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 11,838,759.22 | 7,513,065.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 4,578,909.22 | 3,334,140.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 1,649,500.00 | 3,119,880.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 352,609.00 | 98,965.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 327,760.00 | 253,680.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 4,929,981.00 | 706,400.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 71,351,050.00 | 47,098,900.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 461,050.00 | 355,000.00 |
| 210502 | Хоол, хүнс | 70,890,000.00 | 46,639,900.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 00.00 | 104,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 9,864,990.00 | 2,298,000.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 00.00 | 96,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 9,864,990.00 | 2,202,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 1,286,000.00 | 434,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,286,000.00 | 434,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 2,834,400.00 | 2,899,000.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 2,834,400.00 | 2,899,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 85,341,515.92 | 146,834,591.27 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 5,551,600.00 | 2,228,700.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 400,000.00 | 00.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 79,389,915.92 | 144,605,891.27 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 105,844,238.00 | 41,496,191.88 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 102,157,653.00 | 40,256,756.00 |
| 213202 | Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж | 25,280,453.00 | 1,584,156.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 00.00 | 25,161,000.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 12,464,800.00 | 00.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 47,936,400.00 | 12,923,600.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 16,476,000.00 | 588,000.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 3,013,585.00 | 1,239,435.88 |
| 213301 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 00.00 | 511,000.30 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 3,013,585.00 | 728,435.58 |

| | | | |
|---|---|---|---|
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 673,000.00 | 00.00 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 673,000.00 | 00.00 |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **900,000.00** | **00.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 900,000.00 | 00.00 |
| 223001 | Бусад хөрөнгө | 900,000.00 | 00.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **36,153,170.48** | **57,187,775.65** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | 00.00 | 39,132,529.60 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 00.00 | 11,117,919.34 |
| 225007 | Хөрөнгийн дахин үнэлгээний зардал | 00.00 | 28,014,610.26 |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | 00.00 | -39,132,529.60 |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **36,153,170.48** | **18,055,246.05** |

## 3.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **860,256,863.00** | **799,014,744.30** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **883,210.00** | **500,000.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 883,210.00 | 500,000.00 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 883,210.00 | 500,000.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 860,000.00 | 500,000.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 23,210.00 | 00.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **859,373,653.00** | **798,514,744.30** |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 821,242,600.00 | 789,165,800.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 12,850,600.00 | 7,764,788.30 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 12,850,600.00 | 7,764,788.30 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 25,280,453.00 | 1,584,156.00 |
| 134001 | Нийгмийн даатгалын сангаас санхүүжих | 25,280,453.00 | 1,584,156.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **860,256,863.00** | **799,014,744.30** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **860,256,863.00** | **799,014,744.30** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **732,997,225.00** | **756,360,552.42** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 477,551,517.00 | 503,907,620.42 |
| 210101 | Үндсэн цалин | 370,152,356.00 | 393,588,911.70 |
| 210102 | Нэмэгдэл | 78,463,700.00 | 81,328,209.00 |
| 210104 | Урамшуулал | 28,935,461.00 | 28,990,499.72 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 52,510,960.00 | 58,334,590.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 41,572,380.00 | 40,727,764.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,187,716.00 | 3,900,982.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,734,645.00 | 4,116,891.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 546,929.00 | 972,186.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 5,469,290.00 | 8,616,767.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 106,064,154.00 | 105,839,704.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 8,365,114.00 | 6,965,314.00 |
| 210302 | Түлш, халаалт | 95,959,640.00 | 98,244,390.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,739,400.00 | 630,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 7,393,969.00 | 5,710,215.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,166,470.00 | 900,320.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 2,254,800.00 | 2,253,930.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 355,399.00 | 241,965.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 1,388,800.00 | 729,400.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 2,228,500.00 | 1,584,600.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2105** | **Нормативт зардал** | 56,448,450.00 | 47,107,250.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 465,050.00 | 353,800.00 |
| 210502 | Хоол, хүнс | 49,351,400.00 | 45,731,850.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 6,632,000.00 | 1,021,600.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 11,712,155.00 | 2,489,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 11,712,155.00 | 2,489,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 1,286,000.00 | 434,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,286,000.00 | 434,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 12,980,000.00 | 8,746,788.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 12,980,000.00 | 8,746,788.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 7,050,020.00 | 23,791,385.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 6,650,020.00 | 6,161,385.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 400,000.00 | 17,630,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **127,259,638.00** | **42,654,191.88** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 123,573,053.00 | 41,414,756.00 |
| 213202 | Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж | 25,274,453.00 | 1,584,156.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 21,458,900.00 | 26,319,000.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 12,464,800.00 | 00.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 47,898,900.00 | 12,923,600.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 16,476,000.00 | 588,000.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 3,013,585.00 | 1,239,435.88 |
| 213301 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 00.00 | 511,000.30 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 3,013,585.00 | 728,435.58 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 673,000.00 | 00.00 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 673,000.00 | 00.00 |
| **7** | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **00.00** | **00.00** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 00.00 | 00.00 |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 00.00 | 00.00 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 00.00 | 00.00 |

## 3.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| D01 | **2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **784,407,989.49** | **247,052,883.01** | **-34,464,298.41** | **00.00** | 996,996,574.09 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **784,407,989.49** | **247,052,883.01** | **-34,464,298.41** | **00.00** | 996,996,574.09 |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 00.00 | -74,218,671.99 | 00.00 | 00.00 | -74,218,671.99 |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 40,576,000.00 | 00.00 | 18,055,246.05 | 00.00 | 58,631,246.05 |
| D09 | **2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **824,983,989.49** | **172,834,211.02** | **-16,409,052.36** | **00.00** | 981,409,148.15 |

## 3.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Өмнөх оны | | Тайлант оны | |
|---|---|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | **0.0** | **0.0** | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 821,742,600.00 | 819,089,015.00 | 789,665,800.00 | 788,937,364.42 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 821,742,600.00 | 819,089,015.00 | 789,665,800.00 | 788,937,364.42 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 722,608,500.00 | 720,790,415.00 | 750,925,900.00 | 749,106,764.42 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 479,040,700.00 | 477,551,517.00 | 503,844,500.00 | 503,907,620.42 |
| 210101 | Үндсэн цалин | 371,586,400.00 | 370,152,356.00 | 396,390,200.00 | 393,588,911.70 |
| 210102 | Нэмэгдэл | 78,463,700.00 | 78,463,700.00 | 78,463,700.00 | 81,328,209.00 |
| 210104 | Урамшуулал | 28,990,600.00 | 28,935,461.00 | 28,990,600.00 | 28,990,499.72 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 52,694,300.00 | 52,504,960.00 | 58,553,500.00 | 58,334,590.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 33,532,800.00 | 41,566,380.00 | 39,035,600.00 | 40,727,764.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,832,300.00 | 2,187,716.00 | 4,879,400.00 | 3,900,982.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 4,790,400.00 | 2,734,645.00 | 3,903,700.00 | 4,116,891.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 958,000.00 | 546,929.00 | 975,900.00 | 972,186.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 9,580,800.00 | 5,469,290.00 | 9,758,900.00 | 8,616,767.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 106,067,600.00 | 106,064,154.00 | 106,386,700.00 | 105,839,704.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 8,365,800.00 | 8,365,114.00 | 7,511,600.00 | 6,965,314.00 |
| 210302 | Түлш, халаалт | 95,961,800.00 | 95,959,640.00 | 98,245,100.00 | 98,244,390.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,740,000.00 | 1,739,400.00 | 630,000.00 | 630,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 7,410,000.00 | 7,370,759.00 | 6,070,600.00 | 5,710,215.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,106,800.00 | 1,143,260.00 | 943,700.00 | 900,320.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 2,256,300.00 | 2,254,800.00 | 2,027,600.00 | 2,253,930.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 381,600.00 | 355,399.00 | 801,400.00 | 241,965.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 1,436,800.00 | 1,388,800.00 | 713,300.00 | 729,400.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 2,228,500.00 | 2,228,500.00 | 1,584,600.00 | 1,584,600.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 56,449,200.00 | 56,448,450.00 | 47,792,600.00 | 47,107,250.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 465,500.00 | 465,050.00 | 377,400.00 | 353,800.00 |
| 210502 | Хоол, хүнс | 49,351,400.00 | 49,351,400.00 | 46,393,100.00 | 45,731,850.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 6,632,300.00 | 6,632,000.00 | 1,022,100.00 | 1,021,600.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 11,714,700.00 | 11,712,155.00 | 2,489,500.00 | 2,489,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 11,714,700.00 | 11,712,155.00 | 2,489,500.00 | 2,489,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 1,366,500.00 | 1,286,000.00 | 444,200.00 | 434,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,366,500.00 | 1,286,000.00 | 444,200.00 | 434,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 805,700.00 | 802,400.00 | 1,493,700.00 | 1,493,000.00 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 805,700.00 | 802,400.00 | 1,493,700.00 | 1,493,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 7059800.00 | 7050020.00 | 23850600.00 | 23791385.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 6,659,800.00 | 6,650,020.00 | 6,157,000.00 | 6,161,385.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 400,000.00 | 400,000.00 | 17,693,600.00 | 17,630,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 99134100.00 | 98298600.00 | 38739900.00 | 39830600.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 99,134,100.00 | 98,298,600.00 | 38,739,900.00 | 39,830,600.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 21,463,000.00 | 21,458,900.00 | 25,227,600.00 | 26,319,000.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 13,295,900.00 | 12,464,800.00 | 00.00 | 00.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 47,898,900.00 | 47,898,900.00 | 12,923,600.00 | 12,923,600.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 16,476,300.00 | 16,476,000.00 | 588,700.00 | 588,000.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 821,742,600.00 | 819,089,015.00 | 789,665,800.00 | 788,937,364.42 |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 821,242,600.00 | 818,589,015.00 | 789,165,800.00 | 788,437,364.42 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 821,242,600.00 | 818,589,015.00 | 789,165,800.00 | 788,437,364.42 |
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | 500,000.00 | 500,000.00 | 500,000.00 | 500,000.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 500,000.00 | 500,000.00 | 500,000.00 | 500,000.00 |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 55.00 | 55.00 | 55.00 | 55.00 |
| 620001 | Удирдах ажилтан | 04.00 | 04.00 | 04.00 | 04.00 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 36.00 | 36.00 | 36.00 | 36.00 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 15.00 | 15.00 | 15.00 | 15.00 |
| **63** | **СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)** | 612.00 | 612.00 | 588.00 | 590.00 |
| **630** | **ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД** | 612.00 | 612.00 | 588.00 | 590.00 |
| 630001 | Төрийн өмчит ЕБС | 612.00 | 612.00 | 588.00 | 590.00 |